

2025 оны 01 сарын 24 өдөр

№ BR 25/.....<sup>001</sup>

Улаанбаатар

**“ТЭНГЭР ДААТГАЛ” ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг  
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 61 дугаар зүйлийн 61.1.5 дах хэсэг, 60 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.3 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2 дох хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” болон, “Тэнгэр Даатгал” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрэм (цаашид “Дүрэм” гэх)-ийн 6.3-р зүйлийн 6.3.1, 6.3.4 болон 6.3.7 дах хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2025 оны 03 сарын 06-ны өдрийн 12:00 цагаас Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу, Галлериа Улаанбаатар төв, 3-р давхар, "JUULCHIN SKY BALLROOM"-д хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг [www.investmentexpo.mn](http://www.investmentexpo.mn) вэбсайтаар хэрэгжүүлсүгэй.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
  - 3.1 Компанийн шинэчлэгдсэн дүрэм батлуулах;
  - 3.2 Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны төсөв батлах;
  - 3.3 Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 02 сарын 13-ны өдрөөр тасалбар болгон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр хийлгэсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг энэхүү тогтоолын **Хавсралт №1**-ээр баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг 2025 оны 02 сарын 06-ны өдөр болон 2025 оны 02 сарын 19-ний өдрүүдэд өдөр тутмын сонинд, Компанийн [www.tengerdaatgal.mn](http://www.tengerdaatgal.mn) вэбсайт болон Монголын хөрөнгийн биржийн [www.mse.mn](http://www.mse.mn) цахим хуудсаар 2025 оны 01 сарын 29-ний өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой Хувьцаа эзэмшигчдийн танилцвал зохих мэдээлэл, баримт бичгийн жагсаалтыг **Хавсралт №2**-оор баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга болон загварыг **Хавсралт №3**-аар

баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд уг саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа нь 2025 оны 03 сарын 05-ны өдрийн 12 цаг 00 минут хүртэл байна.

8. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан 2025 оны 01 сарын 27-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, энэхүү тогтоолын Хавсралт №1 болон Хавсралт №2 дахь мэдээлэл болон Компанийн тухай хуулийн 80.11-т заасан мэдээллийн хамт хүргүүлсүгэй.
9. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан Хавсралт №2-оор баталсан мэдээлэл, баримт бичгийн төслийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр 2025 оны 02 сарын 01-ний өдрийн дотор Хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компаниудад хүргүүлсүгэй.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ш.Паравпэлжээ овогтой Гантуяаг томилсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар батлах тогтоолын төслийг Хавсралт №4-өөр баталсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг Хавсралт №5-аар баталсугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох төлөөлөгчийн итгэмжлэлийн загварыг Хавсралт №6-аар баталсугай.
14. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга Балдан овогтой Энхтүвшинд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ш. ГАНТУЯА